



Ж.Санжаа, доктор (Sc.D), профессор
Г.Батзаяа, доктор (Ph.D), дэд профессор

ТОГТОЛЦООНЫ ОНОЛ ХИЙГЭЭД ФОНЕМЫН ОНОЛЫН АСУУДАЛД

Резюме: В последнем веке больше всех развивается теория и методика общей системы в философии востока и запада а также в социально-естественной науке.

Опираясь на динамико-релятивную теории фонемы монгольской лингвистики, на основе этого мы сформулировали всеобщую динамико-релятивную теорию гиперфонемы монгольских языков.

Если рассматривать из этой теории языковые единицы являются с одной стороны хотя градационной системой – из простого к сложным, из малого к большим, но с другой стороны они является единицей системы нелинейного единства со стороны артикуляции, акустики, сигнификативной функции и энергии, который имеет взаимозависимый характер между собой и эти единицы замещает и растворяется друг с другом.

Түлхүүр үг: Квант физик, дундад үзэл, хоосон чанар, нөхөх зарчим, энерги эрчим хүч, фонемын хөдлөнгө - харьцангуйн онол, их авиалбар (гиперфонем) - ын хөдлөнгө - харьцангуйн түгээмэл онол

Хүн төрөлхтөн Чарльз Дарвины (1809-1882) хувьслын онолоос хойш нэгэн зууны туршид атомын эринг (1890-1970) - г туулж, 1970-аад оноос хойш мэдээллийн эринтэй золгохдоо олон нээлт хийж, цөөнгүй шинэ онол боловсруулсныг байгаль, нийгмийн салбарын судалгааны онол - аргазүйн хөтөч болгон шинжлэх ухаан тус бүр улам хөгжсөөр байна.

1. Тогтолцооны онол-аргазүйн тухайд

Хэлийг судлах нь байгаль нийгэм, хүн төрөлхтөний язгуур мөн чанар, хөгжил хувирлын зүй тогтлыг судалдаг бодисзүйн ухаан, гүн ухаантай салшгүй холбоотой юм.

Учир нь хэл нь нийгмийн ч үзэгдэл, байгалийн ч үзэгдэл. Хүний хэлэх, ярих чадвар тархины төрмөл шинжтэй (Чомский, 2000). Хүний уураг тархи хэлийг ашиглаж чаддаг болсон тэр цагт л хэл нийгмийнх болжээ (Ж.Вандриес, 2004), (А.А.Леонтьев, 2010).

1920-1930-аад оны үед Австрийн онолын физикч Эрвин Шрёдингер (1887-1961)-ийн долгионы механик, Вэрнэр Хайзенбэргийн (1901-1976) матрицийн механик гэсэн хоёр тогтолцоо буй болж, эхнийх нь электроныг бөөм гэж, хоёр дахь нь долгион хэмээн үзэж байлаа. Хоёр онол хоёулаа үнэн болох нь туршлагаар батлагдаад байсан (Физик, 2012) ийм үед парадокс (гаж гэмээр) үзэгдэлтэй физикчид нүүр тулаад байсан тэр цаг үед квант хувьслыг үндэслэгчдийн нэгэн Данийн эрдэмтэн Нильс Бор (1885-1962) “Нөхөх (гүйцээх) хийгээд зохилдохын зарчим”-аа боловсруулж тавьсныг өрнийн зарим эрдэмтэн “Хүн төрөлхтөний сэтгэлгээний хувьслын шинэ шат болсон” хэмээн хэтрүүлэн үнэлсэн тал ч байдаг. Харин Нильс Бор “нөхөх (гүйцээх) хийгээд зохилдохын зарчим”-аа энэ зарчим байгалийг судлахад саад болох биш, харин түүний чухал чанар тул үүнийг ойлгоход шинэ логик шаардана гэж даруухнаар тайлбарлаж байжээ. Данийн Фредериксборг шилтгээнд байрлуулсан Н.Борын сүлд нь бамбай дээрх дугуйд хар, цагаан өнгөөр ялгасан дорно дахины гүн ухааны арга билгийн ёсны хос загас бүхий дүрстэй, түүний дээр бичсэн титэм үг нь “Contraria Sunt Complementa”, латин хэлнээс нь орчуулбал “Үл нийцэх нь (үл зохилдох нь) нөхөхийн үндэс” хэмээх утгатай байдаг нь чухамдаа өрнө, дорно дахины шинжлэх ухааныг зохилдуулан нөхөх тухай шинжлэх ухааны аргазүйг сайшаан бэлгэдсэн уриа мэт бодогдоно.

Дорно дахины гүн ухааны дундад үзэл,

хоосон чанар, арга билгийн шүтэлцээний онол нь өрнө дахины бодисзүйн шинжлэх ухаан хийгээд бусад шинжлэх ухааны онол, нээлтийн үр дүнтэй дүйцэж байгааг нотолсон эрдэм судалгааны шинэхэн хандлага ч төлөвшиж байна. Дорно дахины хийсвэрлэх сэтгэлгээний үр дүн, өрнө дахины туршин мэдрэх судалгааны үр дүн эдүгээ нийлэн нэгдэж байгаа нь Германы физикч Альберт Эйнштейн (1879-1995)-ий “Харьцангуйн онол”, Австралийн онолын физикч Эрвин Шрёдингэр(1887-1961)-ийн “Шрёдингэрийн муур” хэмээх оюуны туршилт (Дэвис, 2009), Германы эрдэмтэн онолын физикч Вэрнэр Хайзэнбэргийн (1901-1976) “Тодорхойгүйн зарчим”, Германы физикч Г.Хакен (1929-)-ы “Өөрөө цэгцрэх тогтолцооны онол-синергетик”, Монголын академич Ш.Лувсанвандан (1910-1983)-ы “Фонемын хөдлөнгө - харьцангуйн онол” зэргээр улам бүр батлагдаж байна.

XX зуунд өрнө дахины бодисзүйн шинжлэх ухаанд гарсан гарамгай нээлт онолыг зөвшөөрөн үнэлж, тайлбарлах нь зөвхөн байгалийн шинжлэх ухаан төдийгүй нийгмийн шинжлэх ухаан, биологийн ухаан, гүн ухаан, хэл шинжлэл зэрэг бүхий л шинжлэх ухааны салбарыг хамарсан аргагүйн ач холбогдолтой онол болон хөгжиж байна. Тухайлбал, Австрийн биологич Людвиг Вон Бергаланфи (1901-1972) бодит юм, биологийн биет, нийгэм нь изоморфизм (адил тэгш, нийтлэг) - ийн шинжтэй, эрчим мэдээлэл солилцдог ерөнхий тогтолцоотой болохыг нээсэн ажээ.

Германы физикч Г.Хакен нарын үндэслэсэн ертөнцийн юмс үзэгдэл өөрөө аяндаа эмхрэн хөгждөг шугаман бус хөгжлийн зүй тогтлыг судалдаг синергетика (харилцан үйлчлэх, шүтэн нэгдэх, эвсэн нөхөрлөх) - ийн шинжлэх ухааны өөрөө цэгцрэх тогтолцооны онол нь шинжлэх ухааны олон салбарт судалгааны онол аргагүй болж байна (Ц.Өнөрбаян, 2009).

XX зууны сүүл хагасаас эхлэн эрдэмтэд цаг агаар, усны үер, лааны утаа зэргийн урсгал тодорхой нэгэн цэгээс эхлэн хурд, чиглэлийн зөрөө нь улам ихэссээр эмх замбараагаа алдан хуйлраа үүсгэдэг, таамаглахын аргагүй шинж төлөвийг илэрхийлдэг үзэгдлийг судалж, үр дүнг “Хаосын онол” хэмээн нэрлэв. Францын физикч, математикч Анри Пуанкарэ (1854-1912) нарын ажлаас эхтэй хаос онолыг хоорондоо холбоогүй шинжлэх ухааны олон салбарт зэрэг зэрэг нээсэн нь энэ онол аливаа судалгааны чухал аргагүй болох чадавхтай болохыг харуулж байна. Эдүгээ

бодисзүйн ухааны эрдэмтэд байгалийн үндсэн гурван хүч цахилгаан соронзон, хүчтэй харилцан үйлчлэл, сул харилцан үйлчлэлийг нэгтгэх оролдлого бүхий “Их нэгдлийн онол”, дээрх гурван хүч дээр гравитацийг нэмээд байгалийн дөрвөн хүчийг нэгтгэн тайлбарлах зорилготой “Бүхний онол” хийгээд “Утаслагийн онол”-д ихээхэн хүч хөдөлмөрөө зарж байна.

Монгол улсын нэрт сэтгэгч, гүн ухаанч, хэл шинжээч, академич Ш.Лувсанвандан (1910-1983) физикийн шинжлэх ухааны нээлт онолыг тогтолцооны онолын үүднээс шинжлэн судалж, хэл бол байгаль нийгмээр үлгэр болгосон дохионы тогтолцоо хэмээн үзэж “Хүний хэл нь байгаль нийгмийн үзэгдлийн аль алинтай нягт уялдсан маш нарийн төвөгтэй үзэгдэл юм. Хэл бол хүний өгүүлэх эрхтэний хөдөлгөөнөөр гарах хийн урсгалаар илэрч бүтэх байдлаараа байгалийн үзэгдэл боловч хүний саналаа солилцох харилцааны хэрэглүүр болох үүргийн хувьд нийгмийн үзэгдэл болно. Хэлний бүтцийг үзэхэд байгаль, нийгэмтэй төстэй зүйл олон байна. Хэлний нэгж нь байгаль, нийгмийн юм үзэгдлийг орлосон нэг зүйлийн дохио юм” хэмээн томъёолж, үүнийгээ өрнө дахины харьцангуйн онол, дорнын дундад үзэлтэй хослон “Фонем, морфемын хөдлөнгө - харьцангуйн онол”-оо дэвшүүлэн тавьсан билээ.

Өрнө дахин, дорно дахины сэтгэгчид, эрдэмтэд орчлон ертөнцийг таних аргагүй нь ч, арга нь ч өөр өөр байсан хэдий ч нэгэн адил зорилгыг өвөрлөсөн учраас өнөөдөр харах нь ээ, тэдний сэтгэлгээ, оюун бодролын үр дүн болон туршилт нээлт нэгэн цэгт нийлж, нэгдмэл дүгнэлтэд хүрч байгаа нь зүй ёсоор анхаарал татаж байна. Өрнө дахин орчлонгийн бодислог чанарт нь, дорно дахин бодислог бус хийсвэр чанарт нь шүтэж, өрнөдөд ил бодит юмсыг зөвшөөрч, далд ертөнцийг үгүйсгэсэн үзлээр хөтөч хийсэн бол дорнодод орчлонгийн жам ёсыг мэдрэмж, билгийн мэлмийгээрээ танин гэгээрэлд хүрэх үзлээр хөтөч хийжээ. Иймээс ч өрнөдийнхөн аливаа юмс үзэгдлийг аргын сэтгэлгээгээр, эгэл нэгж болгон салгаж судлаад, дараа нь нэгтгэн дүгнэсээр өнөөгийн шинжлэх ухаан, технологийн гайхам амжилтад хүрч чаджээ. Дорнынхон аргын бус билгийн сэтгэлгээгээрээ ил болон чинад ертөнцийн мөн чанарыг адил хэмээр ухааран, бид бүхний харж мэдэрч байдаг энэ дэлхий, ертөнц болбоос орчлонгийн язгуур оршихуйн мөн чанар бус, харин энэ бодит юмс үзэгдэл нь сүүдэр мэт, хий хоосон зэрэглээ мэт бөгөөд түгээмэл үндэс нь

хоосон чанартайг илрүүлэн тайлжээ.

Хэдийгээр дорно дахинд эгэл бөөмсийг эвдэлж буталж туршилт хийгээгүй ч оюун ухаан, хийсвэр сэтгэхүй, гэгээрлийн ачаар ертөнцийн эгэл хэсэг цааш цаашид хуваагдах хязгааргүй боломжтойг аль эрт нээсэн ажгуу. Өөрөөр хэлбэл, хамгийн эгэл хэсгийн түвшинд ч бүх юмс хувирамтгай, харьцангуй, бодит бус чанартай байна, түүнээс цааш ч задрах чанартай; хувирдаггүй, хуваагдах боломжгүй хэсэг байхгүй хэмээх буддын гүн ухааны онол, квант физикийн нээлттэй тохирч байна гэсэн үг. Дорно дахинд гүн ухааны язгуур суурь зарчим нь нэгдэл, өрнө дахинд үүний эсрэг тэмцэл “Дорнынхон аливаа юмсын харилцаа хамаарлыг чухалчилж, үйл үгээр илэрхийлдэг, өрнийнхний хувьд объектыг илүүд үзэж, нэр үгээр илэрхийлдэг онцлогтой (Хэл шинжлэл “Соёмбо” нэвтэрхий толь, 2012) юм бол бид бие биеэ оюуны сав, ухааны чадамжаараа нөхөх цаг нэгэнт болж, энэ боломж мэдээллийн эдүгээ зуунд бүр ч өргөжлөө.

Иймээс академич О.Лхагвын тэмдэглэснээр “Орчлонгийн цэг бүрт л бүх мэдээллийг нь хувирахуйн жам зүйтэй нь цуг шүглүүлж шингээсэн холограф (багсрахуй) оршихуй орогнох ажээ.” (О.Лхагва, 2015)

2. Академич Ш.Лувсанвандангийн хэл шинжлэлийн сэтгэлгээний онол-аргазүйг баяжуулан хөгжүүлсе

Академич Ш.Лувсанвандан “Мадхъямака хэмээх дундад үзэл” (1977) хэмээх өгүүлэлдээ диалектик аргаар дундад үзлийг тайлбарлаж “Дундад үзэлтэн нь өөрсдөө бол аливаа юм үзэгдлийг түрдэхгүй, төрөхгүй; мөнхгүй, тасархайгүй; нэгэн чанарт бус, өөр чанарт бус; ирэхгүй, одохгүйн дунд байх хоосон чанар гэж үздэг ажээ. Өөрөөр хэлбэл, аливаа юм үзэгдэл нь бүтэхийн хамт эвдэрч, эвдрэхийн хамт бүтэж, үргэлжлэхийн хамт тасарч, тасрахын хамт үргэлжилж, салахын хамт нийлж, нийлэхийн хамт салж, үгүй болохын хамт буй болж, буй болохын хамт үгүй болж байдаг эсрэг тэсрэг зөрчлийн нэгдэл юм гэдэг байжээ. Давтан хэлбэл, дундад үзэл нь аливаа юм үзэгдлийг ганц зогсонги талаас нь биш, мөн ганц хөдлөнгө талаас нь ч биш, зогсонги хөдлөнгө хоёр талаас нь бүхэл болгож харах гэсэн үзэл юм” гэж тодорхойлжээ. (Ш.Лувсанвандан, Мадхъямака хэмээх дундад үзэл, 1977)

Их сэтгэгч Нагаржунай (МЭӨ II зуун) хоосон чанарыг бодит ертөнцөөс тасалж, хийсвэр, ерөнхий чанараар нь салгаж

орхисонгүй, харин эл хийсвэр томьёоллоо бодит юм, тодорхой зүйлд шилжүүлэн тайлбарласан нь агуу их нээлт болсон ажээ. Өөрөөр хэлбэл, ертөнцийн юмс үзэгдлийг хийсвэр, бодитойн диалектикаар тайлж, түүнийгээ хувьсамтгай, харьцангуй, шилжимтгий, тогтворгүй, хөдлөнгө харьцаагаар шүтэн барьцалдуулж тайлбарлажээ.

“Орчлонгийн түмэн юм үзэгдлийн мөн чанараас монгол хэлний үзэгдэл ангид бус болохыг билгийн мэлмийгээр тольдон тодорхойёо гийгүүлэн бичиглэсэн, ер Хөх монголын оюун сэтгэлгээний түүхнээ цолгорон цойлсон их мэргэн багштан Шадавын Лувсанвандан” (Ч.Чимэгбаатар, Монгол хэл шинжлэлийн сэтгэлгээг шинэтгэгч эрдэмтэн Ц.Өнөрбаян - IV, 2014) дорнын гүн ухааны “Хоосон чанар”-ын ёсоор хэлний нэгж, түүний харьцааны асуудлыг нягтлан судалж, гүн ухаан дахь мөнхийн үзэл /метафизик/, үгүй гэх тасархай үзэл /нигилизм/, буй үгүй гэх холимог үзэл /эклетик/-ийн аль алиныг шүүмжилж, бүхнийг байнгын хөдөлгөөн, хувирлын явцад нь барьж буулгасан Буддын гүн ухааны дөрвөн үндсэн чиглэлийн нэг болох мадхъямака хэмээх дундад үзлийн үүднээс хэлний түвшин бүрийн тогтолцоо, тэдгээрийн харьцааг тайлбарлаж чадсан эрдэмтэн юм.

Академич Ш.Лувсанвандан хоосон чанарын ёсыг Нильс Борын нөхөх чанарын зарчимтай харьцуулан үзээд, Нильс Борын нөхөх чанарын зарчим, дундад үзэл буюу хоосон чанарын ёс хоёр нь зарчмын хувьд адил юм, мөн Нильс Борын зохилдохын зарчим, дундад үзэлтний түгсэн чанарын зарчим хоёрыг харьцуулан үзээд мөн адил юм хэмээх; мөн Гегелийн “турвалжийн нэгдэл” нь дээд түвшиндээ очоод үндэслэл болдгийн адил дундад үзлийн “хоосон чанар” нь дээд түвшиндээ хоосон бус чанар буюу өнгөн бие болдгоороо адил юм хэмээх дүгнэлтэд тус тус хүрсэн нь санамсаргүй тохиолдол биш ажээ. Тэрбээр “Дундад үзлийн “хоосон чанарын ёс”, Нильс Борын “нөхөх чанарын зарчим” нь их сансар (макрокосмос), өчүүхэн сансар (микрокосмос)-ын түмэн юм, үзэгдэлд түгээмэл байдаг ерөнхий, тусгай, хийсвэр бодитойн харьцааг тусгаж, “түгсэн чанар”, “зохилдохын зарчим” нь дурдсан шинж чанарыг нь хүн хэрхэн танин мэдэх аргыг нь тусгасан мэт санагдана” хэмээн тайлбарлажээ. (Ш.Лувсанвандан, Мадхъямака хэмээх дундад үзэл, 2002)

Академич Ш.Лувсанванданы авиазүйн онол, судалгааг дагнан судалж, эрдмийн зэрэг

хамгаалсан Д.Батцогт Ж.Санжаагийн бүтээлээс эшлэн авч, “Авиагүйч, доктор, профессор Ж.Санжаа нь академич Ш.Лувсанванданы фонемын онол, ялангуяа хэлний нөхөх, үл нөхөх байрлалын зарчмыг цаашид баяжуулан хөгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулжээ” хэмээн үнэлсэн байдаг. (Д.Батцогт, 2010)

Академич Ш.Лувсанвандан “Мадхьямака хэмээх дундад үзэл” (1977) хэмээх өгүүлэлдээ

юмс үзэгдлийн оршин тогтнохын үлгэр болгосон бүдүүвчийг бид дундад үзлийн үүднээс дэлгэрүүлэн загварчлах боломжтой болсноо зэрэгцүүлэн үзүүлбэ.

Академич Ш.Лувсанвандан ертөнцийн юм, үзэгдлийн оршин тогтнохын үлгэр болгож, доорх загварыг үзүүлжээ.

		Юм, үзэгдэл: амьтай, амьгүй бодис, нийгэм, нийгмийн түүх, Дэлхийн соёл гэх мэт			Хоосон чанар, номын бие, ерөнхий хийсвэр нэгдэл /синтез/
Юм, үзэгдлийн оршин тогтох хэлбэр	Чанар, тооны харьцаа	Чанарын харьцаа	Бүтэх	Эвдрэх	Өнгөн бие, хувилгаан бие, тусгай, бодтой
		Тооны харьцаа	Нийлэх	Салах	
	Орон, цагийн харьцаа	Орны харьцаа	Ирэх	Одох	
		Цагийн харьцаа	Үргэлжлэх	Тасрах	
			Зогсох Статистик Тезис	Хөдлөх Динамик Антитезис	

Дундад үзэл, хоосон чанар, квант физикийн онол-аргазүйн үүднээс бидний дэлгэрүүлэн үзүүлж байгаа орчлон ертөнцийн оршин тогтнохын загвар нь:

ОРЧЛОН				
	Бодит ертөнц		Хийсвэр ертөнц	Бодит ертөнц
Юм, үзэгдлийн оршин тогтох хэлбэр	Сав, шимийн ертөнц, түүний амьтай, амьгүй бодис, бие махбод, нийгэм, шинжлэх ухаан, шашин, соёл, хумхи ертөнц		Гравитаци, цахилгаан соронзон, хүчтэй харилцан үйлчлэл, сул харилцан үйлчлэл, биоэнерги, гэрлэн бие (эфирэн бие, аура) сүнс, астрал бие (сэтгэл хөдлөлийн бие), бодол санаа, зөн билиг, зүүд г.м.	Сав, шимийн ертөнц, түүний амьтай, амьгүй бодис, бие махбод, нийгэм, шинжлэх ухаан, шашин, соёл, хумхи ертөнц
Юм, үзэгдлийн оршин тогтох арга	Тусгай, бодитой, хэсэг		Ерөнхий, хийсвэр, бүхэл	Тусгай, бодитой хэсэг
Шүтэн барилдах тоо чанарын харьцаа	Чанарын харьцаа	Бүтэх	Түрдэхгүй, төрөхгүй буюу бүтэхгүй эвдрэхгүй	Эвдрэх
	Тооны харьцаа	Нийлэх	Ангид чанар бус, нэгэн чанарт бус буюу нийлэхгүй салахгүй	Салах

Шүтэн барилдах орон цагийн харьцаа	Орны харьцаа	Үгүй болох	Ирэхгүй одохгүй буюу үгүй болохгүй буй болохгүй	Буй болох
	Цагийн харьцаа	Үргэлжлэх	Мөнхгүй тасархайгүй буюу үргэлжлэхгүй тасрахгүй	Тасрах
Хувьсал, хөгжил		Зогсонги тал	Эс хөдлөх бус, хөдлөх бус буюу зогсохгүй, хөдлөхгүй	Хөдлөнгө тал

ийм байна.

Энэхүү загварыг хураангуйлан дүгнэж хэлбэл, орчлонгийн аливаа юмс үзэгдлийн бүтэх, нийлэх, үгүй болох, үргэлжлэх тал нь зогсонги хийгээд тусгай, бодитой, хэсгийн шинжтэй; эвдрэх, салах, буй болох, тасрах тал нь хөдлөнгө хэдий ч мөн л тусгай, бодитой, хэсгийн шинжтэй бол харин чанарын харьцааг илэрхийлсэн түрдэхгүй төрөхгүй буюу бүтэхгүй эвдрэхгүй; тооны харьцааг илэрхийлсэн ангид чанарт бус, нэгэн чанарт бус буюу нийлэхгүй салахгүй; орны харьцааг илэрхийлсэн ирэхгүй одохгүй буюу үгүй болохгүй, буй болохгүй; цагийн харьцааг илэрхийлсэн мөнхгүй, тасархайгүй буюу үргэлжлэхгүй тасрахгүй хэмээх хоёрдмол тал нь ерөнхий, хийсвэр, бүхэл, хоосон чанартай эс хөдлөх бус хөдлөх бус буюу зогсохгүй хөдлөхгүй шинжтэй ажээ.

Академич Б.Жадамба “0 буюу хоосныг ямар ч тоогоор үржүүлсэн 0 л гарна. ($0 \times 1 = 0$; $0 \times 1500 = 0$ гэх мэт) 1-ийг ямар ч тоогоор үржүүлсэн тухайн тоо л гарна. ($1 \times 1 = 1$; $1 \times 1500 = 1500$ гэх мэт). Тэгэхээр 0 буюу хоосон нь бүх юмсын анхдагч, хамгийн түгээмэл мөн чанар мэт. Харин нэг гэдэг нь аливаа бодит юмсын зохицол, тогтвортой шинжийг илтгэх мэт. Харин $2 \times 2 = 4$; $2 \times 3 = 6$; $2 \times 4 = 8$ гэх мэтээр үржүүлбэл тооны утга нь үржвэрийн тоогоор өснө. Энэ нь аливаа юмсын хөгжил, дэвшил, хөдөлгөөнт чанарыг илтгэх мэт” хэмээн тайлбар хийсэн нь бидний ойлголтыг математикийн хэлээр цэгцлэн томьёолсон мэт санагдана. (Б.Жадамба, Нэг ертөнцийн хандлага бол монголчуудын ертөнцийг үзэх үзэл, монгол хэлний сэтгэлгээний онцлогийн мөн чанар, 2013)

3. Хэлний бага нэгж хийгээд нэгжүүд

Өрнө ба дорнын хэл шинжлэлд хэлний авиаг үгүүлэхийн талаас судлах нь мянга, мянганы өвтэй, сонсгол зүйн талаас судлах нь хэдэн зууны уламжлалтай, үүргийн талаас

судлах нь хэдэн арван жилийн түүхтэй ажээ.

Хэл шинжлэлийн ухааны нэгэн салбар авиазүй нь хэлний авиаг өгүүлэхийн, бодисзүйн, үүргийн талаас судалдаг. Хэлний авиаг өгүүлэхийн талаас судална гэдэг нь чухамдаа байгаль, нийгмийн үзэгдлийн талаас, бодис зүйн талаас судална гэдэг нь орчлон ертөнцийн бусад юм үзэгдлийн адил мөн чанартай болох талаас нь, үүргийн талаас судална гэдэг нь хэлийг нийгмийн үзэгдэл болох талаас нь судалж байна гэсэн үг юм. Аль аль талын судалгаа нь улам боловсронгуй болон хөгжсөөр байна.


Хэл шинжлэлийн ухаанд хэлний хамгийн бага нэгжийг авиа, авиаалбар хэмээдэг боловч түүний оршин тогтнох мөн чанарыг нухацтай судлаагүй, өнгөн, хэлбэр төдий талаас нь тайлбарлаж иржээ. Харин XX зууны шинжлэх ухааны суурь нээлт хийгээд XXI зуунд эрчимжин хөгжиж буй хэл шинжлэлийн салбар ухааны хөгжлөөс үүдэн хэлийг эрчим хүч био энергийн талаас судлахын чухлыг хүний бие дэх мэдээллийг агуулагч торсион талбайн долоон төвийг нээсэн, хүн био энерги эрчмээр дамжин зөн билиг, дотоод ухамсар, билгийн мэлмийгээр мэдээллийг хүлээн авдаг, солилцдог тухай нээлт зүй ёсоор шаардаж байна.

Хүний нийгэм, хүний сэтгэлээс үүдэлтэй эрчим хүч, харилцааны хэлэнд хурж байдаг ажээ. Иймээс дуун ухааны амин сүнс нь авиа, авианы амин сүнс нь үг, үгүүлбэр; үг үгүүлбэрийн амин сүнс нь сэрэл сэтгэхүй бөгөөд хүний хэл яриа гэдэг нь биеийн дотроос амьсгалын түрэлтээр гарч, агаарын хэлбэлзлээр илрэх амьд биеийн биоэрчим хүч ажээ. Өдгөө хүртэл хэлний авиаг мэдрэхүйн таван эрхтэн амтлах (хэл), үнэрлэх (хамар), сонсох (чих), хүртэх (бие махбод), харах (нүд)-ын хүрээнд, агаарын хэлбэлзэл хүний сонсох эрхтэнд хүртэхийн түвшинд хязгаарлан судалж ирсэн нь учир дутагдалтай болж байна.

Бид “Орчин цагийн монгол хэл аялгуунд гиперфонем <фонем> авиа гэсэн гуравласан тогтолцоо байна гэдгийг анх удаа томъёолж, энэхүү тогтолцоо нь гиперфонемын тал буюу ерөнхий, хийсвэр, бүхэл шинжээсээ фонем ба тэдний хувилбарын тал болох тусгай, бодитой хэсгийн шинжрүү; нөгөө талаасаа фонемын хувилбар / авиа болох тусгай, бодитой хэсгийн шинжээсээ фонем, гиперфонем болох ерөнхий, хийсвэр, бүхлийн шинж рүү харьцсан авианы шүтэлцсэн тогтолцоог бүрдүүлэх бөгөөд завсрын шатанд байгаа фонем нь өөр өөрийн хувилбарын тал буюу дотоод харьцааныхаа талаас ерөнхий, хийсвэр, бүхэл, (фонем) мөн боловч, гиперфонемтойгоо харьцахын хувьд тусгай, бодитой, хэсэг зүйл (фонемын хувилбар авиа) мэт болно” хэмээн тэмдэглэсэн нь буй. (Ж.Санжаа, Монгол хэл аялгуунуудын авианы хувирлын түгээмэл зүй тогтол, хэл шинжлэлийн ухааны доктор (Sc.D)-ын зэрэг горилсон бүтээл, 1998) Энэ томъёолол В.Гегелийн “Буй үгүйн дундад болдоггүй нэг ч юм энэ ертөнцөд байхгүй” (Г.В.Ф.Гегель, Сочинение, 1929) хэмээх томъёолол, Нагаржунайн төв үзлийн хоосон чанарын номлол (Г.Лувсанцэрэн, Төв үзэл, төвшин бодлого, 1994), нэрт хэл шинжээч Н.С.Трубецкойн “Авиа саармагших

ёс”- ны онол (Н.С.Трубецкой, 1960), академич Ш.Лувсанвандангийн “Фонемын хөдлөнг харьцангуйн онол”-той нийцэж байгаа юм. (Ш.Лувсанвандан, Фонемын онолын асуудлууд, 2002)

Академич Ш.Лувсанванданы дэвшүүлсэн “Фонемын хөдлөнгө - харьцангуйн онол” -ыг өнөөгийн төрөл монгол хэл аялгуунуудын авианы тогтолцоог судлах хүрээнд түгээмэл утгаар хэрэглэх явцад зөрчилтэй тал илэрснийг бид баяжуулан томъёолсныг судлаач эрдэмтэн Ч.Чимэгбаатар дүгнэхдээ Ж.Санжаагийн судалгааг бүхэлд нь “Фонемын хөдлөнгө-харьцангуйн түгээмэл онол” гэж ерөнхийлөн томъёолж байна. Уг нь бол, бүр нарийвчлаад түүний нээлтийн утга учирт яв цав нийцүүлж “Монгол хэлнүүдийн их авиалбарын хөдлөнгө-харьцангуйн түгээмэл онол” гэж томъёолбол илүү тодорхой, илүү ойлгомжтой байна” хэмээн дурдсан билээ. (Ч.Чимэгбаатар, Монголын хэл шинжлэлийн сонгодог сэтгэлгээ - Ж.Санжаа, III, 2012) Хэлний хамгийн бага нэгжийн үйлчлэх хүрээг илэрхийлсэн түгээмэл онолын гол санааг илтгэсэн бүдүүвчээ давтан үзүүлбэл:



ийм байна.

Ийнхүү авианы эсрэгцэл буюу ялгарлын тогтолцоо нь тус тусдаа биеэ даасан өвөрмөц онцлог бүхий хэл аялгууд биеэ дааж оршин байхын гадаад нөхцөл болдог бол авианы сэлгэцээр шүтэлцсэн гурвалсан тогтолцоо нь нэгэн төрлийн хэл аялгуунууд харилцан нэгдэлтэй байж, харилцан ярилцагчид өөр зуураа саад бэрхшээлгүй ойлголцохын үндэс, амьд хэл оршин тогтнохын дотоод нөхцөл болдог ажээ. Үлгэрлэн өгүүлэхэд, Оросын Ижил мөрний Халимаг, Монголын ойрадууд, Шинжаан, Хөх нуурын ойрадууд өөр хоорондоо; Оросын буриад, Монголын буриад, Хөлөн буйрын буриадууд өөр хоорондоо хэдэн зуун жил туурга тусгаар аж төрж ирсэн боловч одоо хэр учирмагцаа өвөр зуураа саадгүй

шахам ойлголцож, мөн дундын гэмээр халх монголчуудтайгаа бүгдээрээ саадгүй нэвтрэлцэж байгаа нь энэхүү монгол хэлтний авианы гуравласан тогтолцооны дотоод мөн чанарт оршиж байна.

Жишээлбэл, халх, ойрдууд “цус” гэж хэлдэг бол буриадууд “шухан”, өвөрмонгол, монгор, дунсян, бао-ань зэрэг монгол төрөл хэлтнүүд “чус” гэж хэлнэ. Тэгвэл монгол хэлний “ц”, “ш”, “ч” гэсэн тусгай, бодит, хэсэг гурван гийгүүлэгч авиалбар нь энэ тохиолдолд нэг л утгыг зааж, байраараа бие биеэ нөхсөнөөр ц/ш/ч хэмээх хийсвэр, ерөнхий, бүхэл нэгэн их авиалбар болж байгаа юм. Харин нэг нутгийн аялгууны хүрээнд авч үзвэл дээрх гийгүүлэгч тус бүр амьсгалын түрэлттэй, түрэлтгүй хувилбарууд болон задарч тусгай, бодит, хэсэг

авиа болох талаас нь харвал уг гурван авиалбар нь тус тус ерөнхий, хийсвэр, бүхэл зүйл болж байна. Энэ мэт авиа нь өгүүлэгчийн хэлэх байдал, баймж, хам орчин зэрэг хүчин зүйлээс шалтгаалан хязгааргүй олон авианы хувилбар

болон задарч, бас төрөл хэл, алтай язгуурын хэл, ер дэлхийн хэлнүүдийн судалгааны түвшин ахих тусам хязгааргүй нэгдэн их авиалбар үүсгэх боломжтой ажээ.

Жишээлбэл:

Монгол төрөл ба алтай хэлнүүдэд	Орчин цагийн монгол хэл, аялгуунд		
Их авиалбар	Авиалбар	Авиа	
$\left(\begin{array}{l} \text{pсолонгос.pulgin} \\ \text{fмонгол.fulagan} \\ \text{хдагур.xulan} \\ \text{hMM.hulagan} \\ \text{Øхалх.ulTn} \end{array} \right)$	$\left[\begin{array}{l} 6'6ot' \\ \text{ààot}' \\ \text{'ot}' \end{array} \right]$	[6'] ax'	6'6'aw 66ats'Er ààatsar ' 'ot
	$\left[\begin{array}{l} x' \text{ xet}' \\ g \text{ get}' \\ k \text{ ket}' \end{array} \right]$	[x''] ex'	x''x'el x'xets'C g gets'C
		[à]aal	ààal ààats'T 66ats'T ààaTr
		[g]ger	g bog g bogts'R x boxts'R
1 их авиалбар	2 их авиалбар	4 авиалбар	14 авиа

Хэлний хамгийн бага нэгжийн асуудлыг чухамдаа атомыг эгэл нэгж болгон задлаад байгаа квант физикийн нээлт ололтоос үлгэр аван ойлгож болно. Чарльз Дарвин (1809-1882)-ы хувьслын онол, мөн Г.Хакений өөрөө цэгцрэх тогтолцооны онол хийгээд Эдвард Лорэнцийн хаосын “эрвээхийн эффект” гэх хэлц бүхий онолтой дүйцүүлэн тайлбарлаж болох юм.

Байгаль ертөнцийн юмс үзэгдэл нь санамсаргүй, тогтворгүй, эмх цэгцгүй, дэг журамгүй, хэм хязгааргүй тогтолцоо мэт болохыг аливаа хэлний авианы бүрэлдэхүүнийг бүртгэн тоолж бүрэн тогтоох боломжгүй байдагтай дүйлгэн ойлгож болох, мөн байгаль ертөнцийн юмс үзэгдэл тодорхой нөхцөл боломж бүрэлдмэгц биежин тогтворжиж, журамлагдан цэгцэрч, хэмжээ хязгаартай болж, бодитой байдлаар илэрдэг дотоод мөн чанар нь хэлний хязгааргүй авиануудаас хэлний харилцаа, мэдээлэл солилцоход утга ялгах, дохиожуулах үүрэгтэй цөөн хэдэн авиалбарын тогтолцоог ялган тогтоож болдогтой жишин зүйрлэж болох мэт санагдана.

Хэлний хамгийн бага нэгж авиа нь, авианы хувилбарууд (вариант), бусцар авиа (вариация) болж задрах аас гадна, тодорхой авианууд хэлэх, сонсох, үүргийн болон энерги, эрчмийн шинжүүд болж задрах хязгааргүй

боломжтой юм. Авиа задран задарсаар түүний шинж үүрэг нь авиагүй хоосон чанарт шилжиж болох нь тодорхой байна. Өгүүлэх, сонсох шинж нь алдарч, үүргийн чанар нь бусдыгаа нөхнө гэсэн үг. Үлгэрлэвэл, үг авиа хэлэхгүй атлаа нүдний харц, нүүрний хувирал, гарын болон биеийн хөдөлгөөн, амьсгалын хуваарилалт зэргээс хүний санаа бодлыг бүрэн тандаж уншиж болдог баримтыг дурдаж болно. Уг асуудалтай холбон нэгэн домгийг өгүүлбэл: “Бурхан багш, уран дархан Дэсэнжалбарагва хоёул мянган чавхдаст хуурын чавхдасыг нэг нэгээр нь тасдан хаяж хуурдсаар хоёул ганц чавхдастай хуураар хуурдах болжээ. Гэтэл бурхан багш ганц ч хялгасгүй, чавхдасгүй хуураар хуурдаж ялав гэнэ” (Л.Эрдэнэчимэг, 2000)

ДҮГНЭЛТ

Хэлний хамгийн бага нэгж авиа нь өөрөө бүтсэн биш, шүтэлцсэн эгэл нэгжүүдтэй, эдгээр нь хувирч, өөрчлөгдөж шилжиж байдаг, зарим тохиолдолд хоосон чанарт бүрэн шилжих, бусад төрлийн энерги, эрчимд уусан шингэх гэх мэт мөн чанартай тул хэлний бусад нэгж үе, үг, холбоо үг, өгүүлбэр зэрэг нь мөн л ийм шинжийг агуулсан байх нь маргаангүй.

Хэлний хамгийн бага нэгжийг бодис

зүйн ухаан, биологийн ухаан зэргийн “Ерөнхий тогтолцооны онол”, дорно дахины гүн ухааны дундад үзэл хийгээд хэл шинжлэл дэх Ш.Лувсанванданы “Фонемын хөдлөнгө-харьцангуйн онол”, бидний дэвшүүлсэн “Монгол хэлнүүдийн их (хэт) авиалбарын хөдлөнгө-харьцангуйн түгээмэл онол”-ын үүднээс тайлбарлавал, хэлний хамгийн бага нэгж авиа хэмээгч нь их авиалбар, авиалбар, авиа болон тэдгээрийн олон янзын хувилбаруудыг багтаасан бүтэцтэй, хоймсон, гуравласан шүтэлцсэн тогтолцоотой, ил далд биетэй, ерөнхий - тусгай, хийсвэр - бодит, бүхэл - хэсгийн харьцаатай, хэмнэл хөдөлгөөнтэй, хийсвэр хоосон нэгэн дохионы нэгж ажээ.

Иймээс хэлний хамгийн бага нэгж нь нэг харьцаанд авиа ч мөн, авиалбар ч мөн, авиалбарын хувилбар ч мөн, их авиалбар ч мөн, их авиалбарын хувилбар ч мөн; нөгөө харьцаанд авиа ч биш, авиалбар ч биш, авиалбарын хувилбар ч биш, их авиалбар ч биш, их авиалбарын хувилбар ч биш гэсэн бие биеэ үгүйсгэж, бас шүтэлцсэн хөдлөнгө тодорхойлолт дэвшүүлж байгаа юм. Хэлний хамгийн бага нэгжийн дотоод мөн чанар нь бие, хэл, сэтгэлд хурж, гадаад мөн чанар нь дуу авиа, үсэг тэмдэг, дохио зангаагаар илрэх бөгөөд нэг талаас гарт баригдах, нүдэнд үзэгдэх, хэлэнд хүртэгдэх, чихэнд сонсогдох бодитой зүйл мэт боловч нөгөө талаас барьж болохгүй, харж болохгүй, хэлж болохгүй, сонсож болохгүй хийсвэр хоосон чанартай ажээ. Тэгэхээр авиа гэдэг бол сэтгэлийн оронд далд орших хоосон чанарт зүйл ажээ. Гэхдээ энэ нь оргүй хоосон зүйл биш бөгөөд авиа гэдэг нь бодитой талаасаа хумхын тоос, шороо, ус, гал, хий, огторгуй; бас атом, молекул, протон, фотон, бөөмс, энерги эрчим; бас цацраг, гэрэл, туяа, тусгал; бас хэлэхүй, үгүүлбэр, үг, авиа; бас мэдрэмж, ухамсар, бясалгал, зөн билгийн чанартай ажээ.

Ийм учраас хэлний нэгжүүд нь нэг талаас энгийнээс нийлмэл, багаас их болдог шаталсан тогтолцоо мөн боловч нөгөө талаас өөр хоорондоо шүтэн барилдаж, энгийн, нийлмэл; их, бага гэж ялгахын аргагүй, өгүүлэх, сонсох, үүрэг, энерги эрчим хүчний зэрэг олон талаас нь шүтэлцүүлэн тайлбарлаж болох шугаман бус, багцалсан тогтолцоот нэгжүүд ажээ. Үлгэрлэвэл, “уу” хэмээх нэгж нь авиа ч мөн, үг ч мөн, өгүүлбэр ч мөн, эх ч мөн, бас биш юм. Үлгэрлэвэл, “ус” (H₂O) хэмээх элемент нь цас, мөс, уур, манан, будан, цан хүүрэг аль нь ч биш атлаа бас мөн юм, бүгдийнх нь шинжийг хадгалсан мөн чанар

нь юм гэдэгтэй агаар нэг ажгуу.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Вандриес. Ж. (2004). *Язык лингвистическое введение в историю*. Москва
- Ган-Өлзий, Ч. (2015). Буддын төв үзлийн “Хоосон чанар”-ын мэдрэхүйн ухааны тайлал. “Монголын буддын судлалын орчин үеийн асуудал”, 108. Улаанбаатар
- Дэвис, Е. (2009). Квант хувьсгал. *Шинжлэх ухаан - ертөнцийг танин мэдэх хөтөч*, 314-318.
- Леонтьев, А.А. (2010). *Психоллингвистические единицы и порождение речевого высказывания* (р. 6). М.
- Лувсанцэрэн, Г. (1994). *Төв үзэл, төвшин бодлого*. УБ.
- Лхагва, О. (2015). Хоосон чанар ба мөнх тэнгэр. “Дал” сонин, 347/1.
- Лувсанвандан, Ш. (1977). Мадхьямака хэмээх дундад үзэл. “Философийн эрхийн асуудал”, 83-92.
- Лувсанвандан, Ш. (2002). Мадхьямака хэмээх дундад үзэл. “Монгол хэлний авиазүйн онол практикийн асуудлууд”, дөтгөөр дэвтэр, эмхэтгэсэн Ж.Санжаа, 311-323.
- Лувсанвандан, Ш. (2002). Фонемын онолын асуудлууд. “Монгол хэлний авиазүйн онол практикийн асуудлууд”, дөтгөөр дэвтэр, эмхэтгэсэн Ж.Санжаа, 173-207.
- Чимэгбаатар, Ч. (2012). *Монголын хэл шинжлэлийн сонгодог сэтгэлгээ - Ж.Санжаа, III*. УБ.
- Чомский, Н. (2000). *Логические основы лингвистической теории*. М.
- Санжаа, Ж. (1996). Академик Ш.Лувсанвандангийн авиазүйн онолыг баяжуулан хөгжүүлэе. “Монгол хэл шинжлэл”, №1. Улаанбаатар
- Санжаа, Ж. (1998). *Монгол хэл аялгуунуудын авианы хувирлын түгээмэл зүй тогтол, хэл шинжлэлийн ухааны доктор(Sc.D)-ын зэрэг горилсон бүтээл*. Улаанбаатар
- Санжаа, Ж. (2000). *Монгол хэлний авиазүй*. УБ., 175т.
- Трубецкой, Н.С. (1960). *Основы фонологии*. Москва
- Физик. (2012). *Соёмбо” нэвтэрхий толь*, (pp. 138 дахь тал). Улаанбаатар
- Хэл шинжлэл, (2012)., “Соёмбо” нэвтэрхий толь (р. 29). Улаанбаатар